2019 оны 05 сарын 13-ны өдөр Дугаар А/438 Улаанбаатар хот

“Автомашингүй өдөр” зохион байгуулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Автомашингүй өдөр-2019” өдөрлөгийг “Эрсдэлгүй-Эрүүл орчныг хамтдаа” уриан дор зохион байгуулсугай.

2.“Автомашингүй өдөр”-ийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зохион байгуулах үйл ажиллагааг 2 дугаар, дүүргүүдийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх байршил, үйл ажиллагааны чиглэлийг 3 дугаар, автомашингүй өдрөөр амрах томоохон зах, худалдаа, үйлчилгээний газрын жагсаалтыг 4 дүгээр, шаардлагатай зардлыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай:

3.1.Жанжин Сүхбаатарын талбай, Сөүлийн гудамж, Партизаны гудамж, Чоймболын гудамж, Бөмбөгөр худалдааны төвийн уулзвар, Төмөрчний гудамж, Гэсэр сүмийн уулзвар, Самбуугийн гудамж, Анкарагийн гудамж, Бага тойруу, Бээжингийн гудамж, Токиогийн гудамж, Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4 зам хүртэлх туслах зам, Энхтайваны өргөн чөлөөний Зүүн 4 замаас Баруун 4 зам, Чагдаржавын гудамж, Элчингийн гудамж, Гэндэнгийн гудамж, Чингисийн өргөн чөлөөний Монголын хүүхдийн ордны уулзвараас Монгол шуудангийн уулзвар, Сөүлийн гудамж болон дотогш замуудад 2019 оны 05 дугаар сарын18-ны өдрийн 07.00-18.00 цагийн хооронд авто замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба /Д.Амарсайхан/, нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэлд зохицуулалт хийхийг Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар /Х.Булгаа/-т тус тус;

3.2.“Автомашингүй өдөр”-өөр авто замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарласан замын гарцыг хааж, хамгаалалтын болон нэмэлт тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, замын эвдрэл гэмтлийг засаж, янзлах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/, “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т тус тус;

3.3.“Автомашингүй өдөр”-өөр иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулан, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/, хөдөлгөөн зохицуулж байгаа гэрэл дохиогоор замын хөдөлгөөнийг зохицуулахыг “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ /Д.Одбаяр/-т, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд тус тус;

3.4.“Автомашингүй өдөр”-өөр сонгогдсон талбайд “Эрсдэлгүй-Эрүүл орчныг хамтдаа” уриан дор автомашины хэрэглээг багасгах, өөр төрлийн зорчих хэрэгслийг сонгох, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулахыг иргэд, олон нийтэд уриалж, нийтийг хамарсан уралдаан тэмцээн, соёл, урлагийн арга хэмжээ, худалдаа үйлчилгээ болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлан таниулах талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарт болон дүүргийн Засаг дарга нарт тус тус;

3.5.“Автомашингүй өдөр”-тэй холбогдуулан энэ захирамжийн 4 дүгээр хавсралтад заасан зарим томоохон зах, худалдаа үйлчилгээний төвүүдийг амраан, тухай өдрийн ажлыг дараагийн долоо хоногийн амралтын өдөрт шилжүүлэхээр зохион байгуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т тус тус;

3.6.“Автомашингүй өдөр”-ийг зохион байгуулахад шаардагдах, энэ захирамжийн 5 дугаар хавсралтаар баталсан 26 422 600 /хорин зургаан сая дөрвөн зуун хорин хоёр мянга зургаан зуун/ төгрөгийг нийслэлийн 2019 оны төсөвт тусгасан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсвөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

4.“Автомашингүй өдөр”-ийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, явц, үр дүнг танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаад, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/438 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч	Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга;
	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга;
	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
	Тээврийн цагдаагийн албаны дарга;
	Нийслэлийн Цагдаагийн газрын дарга;
	Нийслэлийн спортын хорооны дарга;
	Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дарга;
	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
	Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;
	Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, Залуучуудын хөгжлийн газрын дарга;
	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;
	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга;
	Нийслэлийн Боловсролын газрын дарга;

“Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ-ын дарга;

“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын дарга;

“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дарга;

Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга;

“Улаанбаатар чуулга“ ОНӨҮГ-ын дарга;

“Монголын хүүхдийн ордон” ОНӨҮГ-ын захирал;

Баянгол дүүргийн Засаг дарга;

Баянзүрх дүүргийн Засаг дарга;

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;

Сүхбаатар дүүргийн Засаг дарга;

Хан-Уул дүүргийн Засаг дарга;

Чингэлтэй дүүргийн Засаг дарга.

Нарийн бичгийн дарга: Нийгмийн нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн салбар хариуцсан мэргэжилтэн

----o0o---

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/438 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР”-ӨӨР ЗОХИОН
БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
2019 05 дугаар сарын 18-ны өдөр			
I.Үндсэн үйл ажиллагаа			
1.	Хотын төв хэсгийн заагдсан замуудад хөдөлгөөнийг хязгаарлах, зохицуулалт хийх	Тээврийн цагдаагийн алба, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ
2.	“Автомашингүй өдөр”-өөр хаасан замын гарцыг хааж, хамгаалалт, нэмэлт тэмдэг байрлуулах, арга хэмжээ дуусахад хэвийн үйл ажиллагаанд оруулах	Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ
3.	Автомашины хөдөлгөөн түр хязгаарласан бүсэд орсон гэрлэн дохионуудыг анивчсан шар гэрлийн горимд шилжүүлэх, бүсийн зааг дээрх хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионуудын горимд түр өөрчлөлт оруулах, хяналт тавьж ажиллах	“Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ	Тээврийн цагдаагийн алба
4.	Хотын төв хэсгийн хаасан замуудаар дайран өнгөрдөг нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн замналд өөрчлөлт оруулах	Нийслэлийн Тээврийн газар	Тээврийн цагдаагийн алба
5.	Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг төөрөх, болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, төөрсөн тохиолдолд хүлээлгэн өгөх, иргэдэд холбогдох мэдээллийг хүргэх, хяналт тавих	Нийслэлийн Цагдаагийн газар	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, Залуучуудын хөгжлийн газар
6.	Өдөрлөгийн үеэр болон дараа нь зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг зохион байгуулах	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, Монголын автомашины холбоод
7.	Нийтийн бие засах газар ажиллуулах, зөөврийн жорлон байршуулж, хяналт тавих	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс	Дүүргийн Засаг даргын тамгын газар, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
8.	“Автомашингүй өдөр”-өөр зах, худалдаа үйлчилгээний төвийн хаагдсан эсэхэд хяналт тавьж ажиллах	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс,	Нийслэлийн Цагдаагийн газар, Дүүргийн Засаг даргын тамгын газар

		Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	
9.	Автомашины хөдөлгөөн хязгаарласан зам талбайд 4 цэгт орчны агаарын чанарын үндсэн хэмжилтийг өнгөрсөн болон ирэх 7 хоногийн нийт 2 удаагийн давтамжтай хэмжилт хийж харьцуулан дүгнэлт хийн танилцуулах	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар	-
10.	“Автомашингүй өдөр”-ийн арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа хэсэгт замын эвдрэл гэмтлийг засварлаж, бэлтгэсэн байх	“Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
11.	Жанжин Д.Сүхбаатарын талбайд болох үйл ажиллагааг цахилгаанаар хангаж ажиллах	“Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
12.	Автомашингүй өдрийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээн дэлгэрүүлэх	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	-
II.Өдөрлөгийн үйл ажиллагаа /Жанжин Д.Сүхбаатарын талбайд/			
13.	Нээлт, хаалтын үйл ажиллагаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар,
14.	Өдөрлөгийн үеэр урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах /Тусгай хөтөлбөрийн дагуу/	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, “Улаанбаатар чуулга” ОНӨҮГ, Юу Би медиа фильм групп,
15.	“Замын хөдөлгөөний цагаан толгой 2019” тэмцээний Улсын аварга багуудын мэндчилгээ /цэцэрлэгийн хүүхдүүд/	Нийслэлийн Боловсролын газар	Тээврийн цагдаагийн алба
16.	Хамгаалалтын бүс, суудлын ач холбогдлын талаар иргэд, олон нийтэд таниулах, сургалт сурталчилгааг явуулах	Тээврийн цагдаагийн алба	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
17.	Өдөрлөгт оролцогсдын дунд АХА асуулт, хариултын тэмцээн зохион байгуулах	Тээврийн цагдаагийн алба	Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар
18.	Зориулалтын унадаг дугуй, хамгаалалтын малгай, хэрэгслийг иргэдэд сурталчлах	Тээврийн цагдаагийн алба	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
19.	Хүүхдийн гар зургийн уралдаан	Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	-
20.	Шүгэлхүү, сэргийлэгч хүү, охин, үлгэрийн баатрууд өдөрлөгт оролцогч хүүхэд, багачуудтай мэндчилэх, татан оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн Цагдаагийн газар	Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн Тээврийн газар, Монголын хүүхдийн ордон, Юу Би медиа фильм групп

21.	Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах	Нийслэлийн Цагдаагийн газар	-
22.	Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг иргэд сурталчлах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар	-
23.	Автомашингүй өдрийн ач холбогдлыг таниулсан, иргэдийг эрүүл зан үйлд уриалсан мэдээлэл, сурталчилгаа явуулах	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тээврийн цагдаагийн алба, Рамониа медиа ТББ
24.	Эерэг сэтгэлгээний давалгаа–алхалт /хөдөлгөөн-эрүүл мэнд хөдөлгөөнт сурталчилгаа/	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн суврага ТББ
25.	Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх дугуйтай хөдөлгөөнт сурталчилгааг зохион байгуулах	Нийслэлийн Эрүүл мэндийн газар,	Тээврийн цагдаагийн алба, Монголын Улаан загалмайн нийгэмлэг
26.	Дугуйн парад /Зам тээврийн аюулгүй байдал, осол гэмтлээс сэргийлсэн хөдөлгөөнт сурталчилгаа/	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Тээврийн цагдаагийн алба, Монголын Оюутны холбоо, Дугуйн холбоо
27.	Хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөн, эрүүл мэндийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Юу Би медиа фильм групп, Бүжгийн холбоо, каратэ,таеквондогийн холбоо,
28.	Өдөрлөгт оролцогч хүүхдүүдийн дунд цаасан шувуу нисгэх уралдаан явуулах	Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	Тээврийн цагдаагийн алба
29.	Иргэдэд зориулсан эрүүл аюулгүй, хоол хүнс, бусад төрлийн үзэсгэлэн, худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
30.	Болзошгүй гамшиг, осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн хичээлийн практик, дадлагад суурилсан байдлаар явуулах	Нийслэлийн Онцгой байдлын газар	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
III.Автомашины хөдөлгөөн түр хязгаарласан бүсэд, заагдсан байршилд /Жанжин Д.Сүхбаатарын талбайгаас бусад/ зохион байгуулах өдөрлөгийн үйл ажиллагаа			
31.	Автомашины хөдөлгөөн хязгаарлагдсан замуудад олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ, иргэдэд зориулсан эрүүл аюулгүй, хоол хүнс, бусад төрлийн үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэдээлэл, сурталчилгаа хийх, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах, зам, замын тэмдэг, тэмдэглээ, талбайг угааж, цэвэрлэх ажлыг зохион байгуулах	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн Биеийн тамир спортын хороо, Дүүргийн Эрүүл мэндийн төвүүд, Дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Дүүргүүдийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/438 дугаар захирамжийн гуравдугаар
хавсралт

ДҮҮРГҮҮДИЙН ИРГЭДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙРШИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

№	Нэр	Байршил	Үйл ажиллагаа явуулах чиглэл
1	Чингэлтэй дүүрэг	Тусгаар тогтнолын талбайд байрлаж, Самбуугийн гудамжны Гэсэр сүмийн уулзвараас Монгол Улсын Их сургуулийн 1 дүгээр байрны уулзвар хүртэлх хэсэгт	-Олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, соёл урлагийн арга хэмжээ, -Иргэдэд зориулсан эрүүл, эко хүнс, бусад төрлийн үзэсгэлэн, худалдаа үйлчилгээ, -Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, сурталчилгаа хийх, -Сургуулийн сурагчдын дунд “Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын тэмцээн, -Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагааг өргөн хүрээнд сурталчлах, -Зам, замын тэмдэг, тэмдэглээ, талбайг угааж, цэвэрлэх ажлыг зохион байгуулах
2	Сүхбаатар дүүрэг	И-март худалдааны төвийн өмнөх талбайд байрлаж, Бээжингийн гудамжинд	
3	Баянзүрх дүүрэг	Бөхийн өргөөний өмнөх талбайд байрлаж, Энхтайваны өргөн чөлөөний Монгол Улсын Боловсролын их сургуулийн уулзвараас Зүүн 4 зам хүртэлх хэсэгт	
4	Хан-Уул дүүрэг	45 дугаар сургуулийн өмнөх талбайд байрлаж, Сөүлийн гудамжинд	
5	Сонгинохайрхан дүүрэг	Улсын их дэлгүүрийн өмнөх талбайд байрлаж, Энхтайваны өргөн чөлөөний Улсын их дэлгүүрийн уулзвараас баруун 4 зам хүртэлх хэсэгт	
6	Баянгол дүүрэг	Бөмбөгөр худалдааны төвийн өмнөх талбайд байрлаж, Жуулчны гудамжинд	

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/438 дугаар захирамжийн дөрөвдүгээр
хавсралт

“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР”-ӨӨР АМРАХ ТОМООХОН ЗАХ,
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Худалдааны төв, худалдаа, үйлчилгээний газрын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил
Чингэлтэй дүүрэг			
1	Бөмбөгөр-1 худалдааны төв	Эрдэнэбулган ХХК Юмт бөмбөгөр ХХК	2 дугаар хороо
2	Бөмбөгөр-2 “Содон” худалдааны төв	Эрдэнэбулган ХХК	2 дугаар хороо
3	Алтжин бөмбөгөр худалдааны төв	Алтжин санаа ХХК	2 дугаар хороо
4	Шонхор зах	Хүчит шонхор ХХК	11 дүгээр хороо
5	Нарантуул-2 худалдааны төв	Анко ХХК	12 дугаар хороо
Баянзүрх дүүрэг			
1	Нарантуул худалдааны төв	Нарантуул трейд ХХК	14 дүгээр хороо
2	Дүнжингарав худалдааны төв	Дүнжингарав ХХК	26 дугаар хороо
3	Өгөөмөр техникийн зах	Собу ХХК	14 дүгээр хороо
4	Сандэй плаза худалдааны төв	Сандэй плаза ХХК	14 дүгээр хороо
5	Шөнийн зах	Нармон ХХК	14 дүгээр хороо
6	Баянзүрх худалдааны төв	Хан талст ХХК	6 дугаар хороо
7	Баянзүрх худалдааны төв-2	Маркет плейс менежмент ХХК	6 дугаар хороо
8	Да хүрээ худалдааны төв	Да хүрээтрейд ХХК	19-р хороо
9	Цайз худалдааны төв	Цайз ХХК	19-р хороо
Сүхбаатар дүүрэг			
1	100 айл орчмын барилгын материалын бүх дэлгүүр		10, 11 дүгээр хороо
2	Меркури худалдааны төв	Гурван эвтэн ХХК	3 дугаар хороо
3	Пассаж худалдааны төв	Монголын Урчуудын эвлэлийн хороо	
Баянгол дүүрэг			
1	Барс худалдааны төв	Барс импекс ХХК	3 дугаар хороо
2	Орхон худалдааны төв	Бат сервис ХХК	6 дугаар хороо
3	Хар хорин худалдааны төв	Хар хорин хүрээ трейд ХХК	20 дугаар хороо
4	Барс-2 худалдааны төв	МВС групп ХХК	20 дугаар хороо

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/438 дугаар захирамжийн тавдугаар
хавсралт

“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зарцуулах үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Нээлт, хаалт, урлаг, спортын тоглолт хийх төв тайз дээвэртэй /10*5/, шат, 10 нүүр хөгжим, микрофон, LED дэлгэц /8*4/	Өдөр	1	4,400,000	4,400,000
2.	Анонс, мэдээллийн жижиг карказ самбар /4*3м 2 ширхэг/ түрээс	Метр	24	15,000	360,000
3.	Тайз, мэдээллийн самбарын чимэглэл /тайз 19м + самбар 24м/	Метр	43	13200	567,600
4.	Тайзны мэдээллийн самбарын анонс хэвлүүлэх /2*3*4/	м2	24	7,500	180,000
5.	Майхан /5*5 хэмжээтэй/ түрээслэх	Ширхэг	14	120,000	1,680,000
6.	Майхны хаяг хэвлэл	Ширхэг	14	12,000	168,000
7.	Талбайн цахилгааны төлбөр	Ширхэг	3	150,000	450,000
8.	Мэргэжлийн найруулагч	Хүн	1	500,000	500,000
9.	Өдөрлөгийн үйл ажиллагааны хөтлөгч /тайз болон талбайн/	Хүн	2	400,000	800,000
10.	Өдөрлөгийн үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, уриалах алиалагч	Хүн	2	200,000	400,000
11.	Үлгэрийн баатрууд, жүжигчид /20 хүний бүрэлдэхүүнтэй/	Хүн	20	50,000	1,000,000
12.	Хөдөлгөөнт сурталчилгааны хулдаасан хэвлэл хэвлүүлэх 1*3м	м2	30	7,500	225,000
13.	Осол гэмтээс сэргийлэх автомашины дүрс бүхий зөөврийн хавтан суурьтай модон рамтай сурталчилгааны самбарын багц	Багц	1	500,000	500,000
14.	Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх постер /А2 календарь/	Ширхэг	5000	940	4,700,000
15.	Эрүүл мэнд-хөдөлгөөн,10000 алхам брошур /А4/	Ширхэг	5000	170	850,000
16.	Хамгаалалтын бүс, хүүхдийн суудлын ач холбогдлыг таниулах брошур /А4/	Ширхэг	5000	170	850,000
17.	Замын хөдөлгөөн цагаан толгой 2019 тэмцээний Улсын аварга багуудын мэндчилгээг дэвшүүлсэн хүүхдүүдийн гарын бэлэг	Хүүхэд	40	20,000	800,000
18.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сурталчилсан АХА тэмцээний үйл ажиллагааг зохион байгуулах /мэргэжлийн хөтлөгч, TV9 телевизээр шууд дамжуулах, нэвтрүүлэг бэлтгэх/	Удаа	1	1,000,000	1,000,000
19.		Том хүн	1-р байр 1	50,000	100,000

	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сурталчилсан АХА тэмцээний шагнал		2-р байр 1	30,000	
			3-р байр 1	20,000	
		Хүүхэд	1-р байр 1	30,000	60,000
			2-р байр 1	20,000	
			3-р байр 1	10,000	
20.	5-10 насны хүүхдүүдийн дунд 2 насны “Зам тээврийн ослоос сэргийлье” сэдэвт талбайн зургийн уралдааны шагнал	1-р байр	2	50,000	100,000
		2-р байр	2	40,000	80,000
		3-р байр	2	30,000	60,000
		Тусгай байр	10	10,000	100,000
21.	Уралдаанд хэрэглэгдэх газрын шохой	Боодол	40	6,000	240,000
22.	Сагсан бөмбөгийн 2 төрлийн тэмцээний шагналын бэлэг	1-р байр	2	20,000	40,000
		2-р байр	2	10,000	20,000
		Тусгай байр	20	800	16,000
23.	Өдөрлөгт оролцогч хүүхдүүдийн дунд зохион байгуулах 2 төрлийн хөгжөөнт тоглоомын бэлэг /Осол гэмтлээс сэргийлэх, автомашингүй өдрийн ач холбогдлыг таниулах/	1-р байр	2	20,000	40,000
		2-р байр	2	10,000	20,000
		Тусгай байр	20	800	16,000
24.	Өдөрлөгийн арга хэмжээнд оролцож, алхалт, хөдөлгөөнт сурталчилгаа, флашмоб хийх оюутан залууст өгөх батламж	Ширхэг	500	650	325,000
25.	Автомашингүй өдрийн арга хэмээг дэмжин оролцсон байгууллагуудад өгөх талархал	Ширхэг	5	35,000	175,000
26.	Автомашингүй өдрийн ач холбогдлыг таниулсан, иргэдийг уриалсан шторк бэлтгэх	Секунд	20	60,000	1,200,000
27.	Автомашингүй өдрийн арга хэмжээг шууд дамжуулах, мэдээ, ярилцлага хийх /TV-5/	Цаг	3	3,000,000	3,000,000
28.	Замын хайс, хашлага шилжүүлэн байршуулах зардал	1080м2	1	400,000	400,000
29.	Хэв журам аюулгүй ажиллагааг хангах цагдаа, цагдаагийн машин ажиллуулах, замын хаалт зөөвөрлөх зардал	600-800	1	500,000	500,000
30.	Замын цагдаагийн машин, мотоцикл, хүн хүч ажиллуулах	250-300	1	500,000	500,000
Бүгд үнэ					26,422,600